

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ -ийн 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, төлбөр олгох, санхүүжүүлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

**Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний
даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн
сэргээлтийн зардлын төлбөр авахад бүрдүүлэх баримт
бичгийн жагсаалт, төлбөр олгох, санхүүжүүлэх журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсэгт заасны дагуу даатгуулагч протез, ортопедийн, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний, сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөр олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Даатгуулагч протез, ортопедийн зардлын төлбөрийг протез, ортопед хийлгэсний дараа холбогдох санхүү (протез, ортопед хийсэн эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрийн төлбөрийн нэхэмжлэх)-гийн баримт болон энэ журмын 2.1-д заасан баримт бичгийг үндэслэн хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан жишиг үнэ (цаашид “жишиг үнэ” гэх)-ээр олгоно.

1.3.Энэ журмын 1.2-т заасан нэхэмжилсэн төлбөрийн дүн нь тухайн протез, ортопедийн жишиг үнээс бага бол нэхэмжилсэн үнийн дүнгээр, их бол жишиг үнийг баримтална.

1.4.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид зөвхөн протез, ортопедийн төлбөрийг олгоно. Протез, ортопедийн засвар үйлчилгээний төлбөр олгохгүй болно.

1.5.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч эрүүл мэндийн даатгалын сангаас, эсхүл нийгмийн халамжийн сангаас протез, ортопедийн, сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний, сэргээн засах төв болон сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг гаргуулсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас зардлын төлбөрийг давхардуулан олгохгүй.

Хоёр. Төлбөр авахад бүрдүүлэх баримт бичиг

2.1. Даатгуулагч протез, ортопедийн зардлын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох төлбөр авах хүсэлтийг доор дурдсан баримт бичгийн хамт оршин суугаа газрын харьяалах аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар (цаашид “Нийгмийн даатгалын байгууллага” гэх)-т цаасаар эсхүл цахимаар ирүүлнэ:

2.1.1.даатгуулагчид протез, ортопед хийх шаардлагатай талаарх Эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын шийдвэр эсхүл Гэмтэл согог судлалын үндэсний төв зэрэг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (цаашид “мэргэшлийн эмнэлэг” гэх)-ийн эмч нарын зөвлөгөөний шийдвэр, дүгнэлт;

2.1.2.протез, ортопед хийлгэсэн эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэх (харилцагч банкны нэр, дансны дугаар, нэхэмжилсэн төлбөрийн дүн;

2.1.3.протез, ортопедийн эдэлгээний хугацаа дуусаагүй боловч зайлшгүй шалтгаан (холгох, нухах, эвдрэл, гэмтэл зэрэг)-аар дахин хийлгэх шаардлагатай бол энэ талаарх мэргэшлийн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөний шийдвэр, дүгнэлт;

2.1.4.хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бол холбогдох нотлох баримт бичиг.

2.2.Сэргээн засах болон сувиллын (цаашид “Сувилал” гэх) тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг авах хүсэлтийг холбогдох байгууллага доор дурдсан баримт, бичгийн хамт харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад цаасаар эсхүл цахимаар ирүүлнэ:

2.2.1.тусламж, үйлчилгээ авсан иргэдийн жагсаалт (овог, нэр, регистрийн дугаар, өвчний онош зэрэг);

2.2.2.төлбөрийн нэхэмжлэх (харилцагч банкны нэр, дансны дугаар, нэхэмжилсэн төлбөрийн дүн.

2.3.Даатгуулагч сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг авах хүсэлтийг унааны зардал төлсөн баримтын хамт харьяалах нийгмийн даатгалын байгууллагад цаасаар эсхүл цахимаар ирүүлнэ.

Гурав.Протез, ортопедийн зардлын төлбөр олгох

3.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 ба түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчийн хийлгэсэн протез, ортопедийн зардлын төлбөрийг энэхүү журмын 1.2-т заасан жишиг үнийг баримтлан 3 жил тутамд нэг удаа олгоно.

3.2.Протез, ортопедийн төлбөр авах даатгуулагч оршин суугаа газрын харьяа нийгмийн даатгалын байгууллагад энэ журмын 2.1.2-т заасан нэхэмжлэх бичигдсэн өдрөөс хойш 4 долоо хоногийн дотор, хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бол 6 сарын дотор хүсэлтээ гаргана.

3.3.Нийгмийн даатгалын байгууллага даатгуулагчийн баримт бичгийг хүлээн авч үндэслэл, бүрдлийг шалгаж шаардлага хангасан бол протез, ортопедийн зардлын төлбөрийг тухайн эмнэлгийн байгууллага болон протезийн үйлдвэрээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийн дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас бэлэн бусаар 14 хоногийн дотор шилжүүлнэ.

3.4.Даатгуулагчийн дараагийн удаагийн хийлгэсэн протез, ортопедийн төлбөрийг олгохдоо энэ журамд заасныг баримтална.

3.5.Энэ журмын 2.1.1-т заасан баримт бичгийг үндэслэн төлбөр олгохдоо хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрийг нийгмийн даатгалын мэдээллийн сангийн үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн актын мэдээллийг холбогдох цахим мэдээлэлд тулгуурлан шалгана.

Дөрөв. Гадаад улсад хийлгэсэн протез, ортопедийн төлбөр олгох

4.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу зайлшгүй шаардлагаар гадаад улсад хийлгэх бол түүний зардлын төлбөрийг энэхүү журмын 1.2-т заасан протез, ортопедийн жишиг үнийг баримтлан 3 жил тутамд нэг удаа олгоно.

4.2.Мэргэшлийн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөнөөр даатгуулагчид протез, ортопедийг гадаад улсад хийлгэх шаардлага, үндэслэлийг тогтоож дүгнэлт гаргах бөгөөд зөвлөгөөний протокол, дүгнэлтийг даатгуулагчийн хүсэлтийн хамт Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Нийгмийн даатгалын ерөнхий газар” гэх)-ын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд (цаашид “Төв зөвлөл” гэх)-т ирүүлнэ.

4.3.Төв зөвлөл нь энэхүү журмын 4.2-т заасан протокол дүгнэлт, хүсэлтийг судлан, тухайн даатгуулагчийн протез, ортопедийг гадаад улсад хийлгэх талаар дүгнэлт гаргана.

4.4.Төв зөвлөл энэ журмын 2.1.1, 4.2-т заасан баримт бичгийг тухайн даатгуулагчийн протез, ортопедийг хийсэн гадаад улсын эмнэлгийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэл /харилцагч банкны нэр, дансны дугаар, нэхэмжилсэн төлбөрийн дүн/-ийг хянан бүрдүүлж харьяа нийгмийн даатгалын байгууллагад дүгнэлтийн хамт хүргүүлнэ.

4.5.Гадаад улсад хийлгэсэн протез, ортопедийн зардлын төлбөрийг энэ журмын 3.2-т заасан хугацаанд Төв зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн тухайн даатгуулагчийн оршин суугаа газрын харьяа нийгмийн даатгалын байгууллага үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тухайн гадаад улсын эмнэлгийн байгууллагад энэ журмын 1.3-т заасныг баримтлан бэлэн бусаар 14 хоногийн дотор шилжүүлнэ. Харин даатгуулагч төлбөрөө өөрөө төлсөн бол баримтыг үндэслэн энэ журамд заасны дагуу даатгуулагчид шилжүүлнэ.

Тав.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардлын төлбөр олгох

5.1.Даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас сувилалд эмчлүүлсэн сэргээн засах болон тусламж, үйлчилгээний хувьсах зардлын батлагдсан хэмжээг баримтлан сувилалд бэлэн бусаар тухай бүр олгоно.

5.2.Энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг үндэслэн зардлын төлбөрийг олгохдоо нийгмийн даатгалын мэдээллийн сангийн цахим мэдээлэлд тулгуурлан даатгуулагч сувилуулсан эсэхийг шалгана.

Зургаа.Сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөр олгох

6.1.Даатгуулагчид сувилалд ирэх, буцах унааны зардлын төлбөрийг тухайн үед мөрдөж байгаа үйлчилгээний үнэ тарифаар энэ журмын 2.3-т заасан баримт бичгийг үндэслэн галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн үнээр бэлэн бусаар олгоно.

6.2.Энэ журмын 2.3-т заасан баримт бичгийг үндэслэн зардлын төлбөрийг олгохдоо нийгмийн даатгалын мэдээллийн сангийн цахим мэдээлэлд тулгуурлан тухайн даатгуулагчийг сувилуулсан эсэхийг шалгана.

Долоо.Санхүүжүүлэх, хяналт

7.1.Энэ журмын дагуу олгох төлбөрийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлнэ.

7.2.Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаад Нийгмийн даатгалын ерөнхий газар, Төв зөвлөл тус тус хяналт тавьж ажиллана.

7.3.Нийгмийн даатгалын байгууллага нь сэргээн засах төв, сувиллын тусламж үйлчилгээний хувьсах зардал, замын зардал, нөхөн олгосон зардалд тус тус хяналт тавьж ажиллана.

Найм.Тайлагнах

8.1.Нийгмийн даатгалын байгууллага нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид олгосон протез, ортопедийн зардлын тайланг сар бүр гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.

8.2.Сэргээн засах төв, сувилал нь тусламж үйлчилгээний хувьсах зардал, замын зардал, нөхөн олгосон зардлын тайланг хагас, бүтэн жилээр дүгнэж дараа сарын 15-ны дотор Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.

Ес.Хариуцлага

9.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oO-----